



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/48

Аргатай

Хязгаарлалтын дэглэмийг
ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.8, 32.1.9 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 266 дугаар тогтоол, Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам, ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Шилийн гол 1 дүгээр багийн дэвсгэр “ Сайн улаан ” хэмээх газарт бог малын гоц халдварт “Мялзан” өвчний сэжиг илэрсэн тул 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр хүртэл хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2. Малын гоц халдварт бог малын “Мялзан” өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд Гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж ажиллахыг Сумын онцгой комиссын орлогч дарга (Р.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.

3. Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүсийн хүн ам, тээврийн хэрэгсэл, малын хөдөлгөөнд хяналт тавьж хэв журам сахиулж ажиллахыг хэсгийн цагдаа (О.Өлзий-Орших), Багийн засаг дарга (М.Мөнгөнхуяг)-нарт үүрэг болгосугай.

4. Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүсэд хийгдэх халдваргүйтгэл, малын эрүүл мэндийн үзлэгийг чанартай хийж, “Мялзан” өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулахыг Энх-Эрдэнэт сүрэг ХХК-ний малын эмч (П.Энхбаатар), Бордарс ХХК-ний малын эмч (Ц.Дуйнхаржав) нарт, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Ц.Ватбилэг) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ЗОЛЗАЯА



482761086